

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Аудит хийх үндэслэл: Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны “Аудитын ажлын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Худалдаа, үйлчилгээ эрхэлж буй иргэн, ААНБ-уудын аль нь зөвхөн сугалааны дугаартай баримт өгөх, ямар нь НӨАТ-тай төлбөрийн баримт өгөх ёстой талаарх мэдээлэл, ойлголт иргэд, олон нийтэд дутмаг байна.



Аудитын нэр:

“Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн”

Баруун-Урт сум
2017 он

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:

ААГ-ын аудитын хэлтэс

Сүхбаатар аймаг

дахь Төрийн

аудитын газрын

дарга, тэргүүлэх М.Нарантуяа
аудитор

Аудитын

менежер

Г.Даваа

Ахлах аудитор

Г.Оюунболд

Аудитор

О.Барчидгүнсэн

Аудитор

Э.Алтансүх

2017 оны 08 дугаар сарын 23-ны өдөр

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал багийн утас 70512123, 70512127

Газрын дарга, тэргүүлэх аудитор 70518396 дугаарын факсаар харилцана уу

ХАЯГ:

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар, Баруун-Урт сум, 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, өрөө №226 тоот

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт 3

Товчилсон үгийн тайлбар 4

1.1. Үйл ажиллагааны борлуулалтын орлого нь НӨАТ-ын босго давсан зарим иргэн, хуулийн этгээд НӨАТ суутган төлөгчөөр хуульд заасан хугацаанд бүртгэгдээгүй нь татварын алба тогтмол хяналт тавьж ажиллаагүйтэй холбоотой байна. 5

1.2. НӨАТ суутган төлөгч иргэн, хуулийн этгээд илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргаагүй тул буцаан олголттой холбоотой татварын хяналт шалгалт хийгдээгүй байна. 7

1.3. НӨАТ-ын хууль тогтоомжид орсон бодлогын өөрчлөлт, шинэчлэлт нь НӨАТ суутган төлөгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа үнэн зөв, ил тод болоход мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлсэн байна. 7

2.1. НӨАТ-ын буцаан олголттой холбоотой гомдол орон нутгийн татварын албанд ирээгүй байна. 8

2.2. Татварын маргаан таслах зөвлөл ирүүлсэн гомдлыг журамд заасан хугацааны дотор хянан шийдвэрлэсэн боловч эрх зүйн үндэслэлгүй акт бичсэн татварын улсын байцаагчид сахилгын шийтгэл ногдуулах саналыг гаргаагүй байна. 8

Аудитын дүгнэлт: 10

Аудитын зөвлөмж: 10

Холбогдох байгууллагын санал 11

Аудитын газрын тайлбар 11

Сүхбаатар аймаг
Баруун-Урт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны “Аудитын ажлын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын дараах чиглэлийг нарийвчлан авч үзэж, үнэлэлт дүгнэлт өгөв. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт тавигдах дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх

Аудит хамарсан хүрээ

Аудитад Сүхбаатар аймгийн Татварын хэлтсээс 2015, 2016 онд хянаж баталгаажуулан байгууллага, иргэдэд олгосон нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын тайлан, статистик мэдээ, судалгаа, бусад баримт бичгүүдийг хамруулан шалгалаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АӨЗ	Ашиглалтын өмнөх захиргаа
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
РД	Регистрийн дугаар
СБА	Сүхбаатар аймаг
СЯ	Сангийн яам
ТЕГ	Татварын ерөнхий газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дэд зорилт-1. Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын бодлого, зохицуулалт үр дүнтэй хэрэгжиж байна уу?

1

БҮЛЭГ 1

НӨАТ-ын хууль тогтоомжид орсон бодлогын өөрчлөлт, шинэчлэлт нь НӨАТ суутган төлөгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа үнэн зөв, ил тод болоход мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлсэн байна.

Үйл ажиллагааны борлуулалтын орлого нь НӨАТ-ын босго давсан зарим иргэн, хуулийн этгээд НӨАТ суутган төлөгчөөр хуульд заасан хугацаанд бүртгэгдээгүй нь татварын алба тогтмол хяналт тавьж ажиллаагүйтэй холбоотой байна.

1.1.1. Сүхбаатар аймгийн татварын хэлтсийн даргын 2016 оны 11 сарын 29-ний өдрийн “Татварын тооцооллын үлдэгдлийг баталгаажуулах тухай” А/20 тоот тушаалаас авч үзэхэд 2015 оны 12-р сарын 31-ний байдлаар НӨАТ-ын илүү төлөлт 125.3 сая, дутуу төлөлт 104.9 сая төгрөг байна.

1.1.2. Аймгийн хэмжээнд 2015 оны жилийн эцсийн байдлаар илүү төлөлттэй байсан НӨАТ суутган төлөгч 175 иргэн, хуулийн этгээд байна. Татварын хэлтсийн үйл ажиллагааны мэдээ, тайлан, татварын улсын байцаагч нартай хийсэн ярилцлага, ирсэн бичгийн бүртгэл зэргийг нэгтгэн авч үзэхэд НӨАТ-ын илүү төлөлттэй байсан НӨАТ суутган төлөгч иргэн, ААНБ-ууд илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргаагүй¹ байна.

1.1.3. НӨАТ-ын тухай хуулийн 13.4-т² заасны дагуу худалдах зориулалтаар шинээр барьсан орон сууцны зориулалттай байрыг худалдан борлуулахад НӨАТ ногдуулна. Сүхбаатар аймгийн хэмжээнд 2016 оны 01 сарын 01-ний өдрөөс хойш борлуулсан шинэ орон сууцнуудын мэдээллийг ХХОАТ-ын 16.1.12-т заасан чөлөөлөлтийн баримт материалаас түүвэрлэн сонгож, улмаар худалдан авагч нараас утсаар тодруулга авахад зарим худалдан авагч нарт НӨАТ-тай төлбөрийн баримт өгөөгүй зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Баруун-Урт сумын 1-р багт Цэлмэг-2 хотхон, Боловсрол хороолол
- Баруун-Урт сумын 2-р багт 30 айлын байр³
- Хувь хүмүүсийн шинээр барьж зарсан 4 айлын орон сууцнууд гэх мэт

¹ НӨАТ-ын илүү төлөлтийг буцаан олгохтой холбоотой хяналт шалгалтыг зөвхөн НӨАТ суутган төлөгч иргэн, хуулийн этгээд хүсэлт ирүүлсэн тохиолдолд хийдэг байна.

² 4.1.7."орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байр" гэж хүн суурьшин амьдрах зориулалттай баригдан уг зорилгоор, аж ахуйн үйл ажиллагааны бус хэлбэрээр ашиглагдаж байгаа бөгөөд энэ хуулийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулсан нийтийн болон амины орон сууцны барилгыг; 13.1.Дараах барааг албан татвараас чөлөөлнө: 13.1.7.орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байр буюу түүний хэсгийг борлуулсны орлого; 13.4.Худалдах зориулалтаар шинээр барьсан орон сууцны зориулалттай байр, түүний хэсэгт энэ хуулийн 13.1.7 дахь заалт хамаарахгүй.

³ Баянгол дүүргийн иргэн худалдан авагч нартай гэрээ байгуулж, борлуулсан байна.

Иймд 2016 оны 01 сарын 01-ний өдрөөс хойш шинэ орон сууц борлуулсан иргэн, ААНБ-ууд нь НӨАТ-аа үнэн зөв тайлагнасан эсэх, НӨАТ-тай төлбөрийн баримтыг худалдан авагч нарт тухай бүр өгсөн эсэх талаар хяналт шалгалт⁴ явуулах талаар Сүхбаатар аймгийн татварын хэлтэст зөвлөмж хүргүүллээ.

1.1.4 НӨАТ-ын тухай хуулийн 6.1⁵-д заасны дагуу хувь хүн, хуулийн этгээдийн уг үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ 50.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн тохиолдолд ажлын 10 өдөрт багтаан албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх өргөдлөө харьяалах татварын албанд гаргахаар байна. Гэтэл зарим хуулийн этгээд хуульд заасан хугацаанаас хойш НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлсэн байна. Үүнд:

- Жигүүрт хүлэг ХХК /РД: 3676072/ нь 2016 оны 1-р улиралд 50.0 сая төгрөгийн босгыг давсан боловч 2016 оны 12 сарын 31-нд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлж, гэрчилгээ авсан.
- Далан шулуун ХХК /РД: 3679853/ нь 2016 оны 2-р улиралд 50.0 сая төгрөгийн босгыг давсан боловч 2016 оны 10 сарын 14-нд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлж, гэрчилгээ авсан.
- Онгон-Арвижих ОНӨҮГ /РД: 3679063/ нь 2016 оны 1-р улиралд 50.0 сая төгрөгийн босгыг давсан боловч 2017 оны 05 сарын 01-нд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлж, гэрчилгээ авсан.
- Халзан дулаан ОНӨҮГ /РД: 8202656/ нь 2016 оны 4-р улиралд 50.0 сая төгрөгийн босгыг давсан боловч 2017 оны 06 сарын 30-нд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлж, гэрчилгээ авсан.

Иймд хуульд заасан хугацаанд НӨАТ-ын суутган төлөгчөөр бүртгүүлээгүй дээрх ААНБ-уудад татварын хяналт шалгалт хийлгүүлэх, дутуу тайлагнасан НӨАТ-ыг нөхөн төлүүлэх талаар албан шаардлага хүргүүллээ.

1.1.5. Олон нийтийн цахим сүлжээ /facebook/-г ашиглан иргэд буюу НӨАТ төлөгч нараас судалгаа авч, үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийж үзэхэд Жавхлант дэлгүүр болон Чимэг дэлгүүр НӨАТ-тай төлбөрийн баримтыг иргэд, худалдан авагч нарт ихэнхи тохиолдолд өгдөггүй талаар дурьдсан байна. Мөн бусад байгууллагуудын хувьд гэр хорооллын дэлгүүрүүд болон сумдын ихэнхи дэлгүүр НӨАТ-тай төлбөрийн баримт өгдөггүй гэжээ. Энэ нь иргэдийн дунд худалдаа, үйлчилгээний байгууллагуудын аль нь НӨАТ суутган төлөгч мөн, аль нь биш болох талаарх мэдээлэл, ойлголт дутмаг байгааг харуулж байна. Түүнчлэн худалдаа, үйлчилгээ үзүүлдэг аль иргэн, хуулийн этгээд нь НӨАТ-тай төлбөрийн баримт өгөх, аль нь зөвхөн сугалааны дугаартай төлбөрийн баримт өгөхийг иргэд олон нийт тэр бүр мэдэхгүй байна. “Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийг

⁴ Тухайн орон сууцыг барьж, борлуулсан иргэн, хуулийн этгээдийн аль татварын албанд бүртгэгдсэн байдлыг харгалзан харьяаллын дагуу шийдвэрлэх, шийдвэрлүүлэх зарчмыг баримтлах нь зүйтэй.

⁵ Энэ хуулийн 4.1.19-д заасны дагуу албан татвар суутгах үүрэг үүссэн хувь хүн, хуулийн этгээд ажлын 10 өдөрт багтаан албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх өргөдлөө харьяалах татварын албанд гаргана.

бүртгэх, бүртгэлээс хасах журам”-ын 6.4⁶-т заасны дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдсэн болон бүртгэлээс хасагдсан хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг татварын албаны цахим хуудсаар улирал бүр мэдээлдэг боловч иргэд, олон нийтэд энэ талаарх мэдээлэл хангалтгүй⁷ байна. Иймд Сүхбаатар аймагт НӨАТ-ын тухай хуульд заасан татвар ногдох үйл ажиллагаа эрхлэн явуулж буй иргэн, хуулийн этгээдүүдийг НӨАТ суутган төлөгч мөн, бишээр нь ангилж⁸ олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд сар бүр тогтмол мэдээлж байх зөвлөмж хүргүүлээ.

1.1.6. Дээрх судалгаанд нэр нь түлхүү дурьдагдсан байгууллагуудын татварын албанд тайлагнасан борлуулалтын орлогыг бусад ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай харьцуулж үзэхэд Жавхлант дэлгүүр буюу “Жавхлант сүхбаатар” ХХК-ийн тайлагнасан борлуулалтын орлогын хэмжээ анхаарал татахуйц бага байгаа нь ажиглагдсан. Иймд тус компанийн НӨАТ төлөлтийн байдалд нэн даруй хяналт шалгалт хийж, шалгалтын үр дүнг мэдэгдэхийг Сүхбаатар аймгийн татварын хэлтэст албан шаардлагаар хүргүүлэв.

1.1.7. Сүхбаатар аймагт НӨАТ-ын сугалааны тохирлын урамшууллаас 500.0 мянга болон түүнээс дээш хонжвор хожсон иргэн 2016 онд 8, 2017 онд 6 байна. Эдгээр иргэдийн холбогдох баримт материалыг хянаж, журамд заасан хугацаанд ТЕГ-т хүргүүлсэн байна.

НӨАТ суутган төлөгч иргэн, хуулийн этгээд илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргаагүй тул буцаан олголттой холбоотой татварын хяналт шалгалт хийгдээгүй байна.

1.2.1. Сүхбаатар аймгийн хувьд 2015 оны жилийн эцсийн байдлаар илүү төлөлттэй байсан НӨАТ суутган төлөгч 175 иргэн, хуулийн этгээд илүү төлөлтөө буцаан авах хүсэлт гаргаагүй тул буцаан олголттой холбоотой татварын хяналт шалгалт хийгдээгүй байна.

НӨАТ-ын хууль тогтоомжид орсон бодлогын өөрчлөлт, шинэчлэлт нь НӨАТ суутган төлөгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа үнэн зөв, ил тод болоход мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлсэн байна.

1.3.1. НӨАТ-ын хууль тогтоомжид дараах бодлогын өөрчлөлт орсон. Үүнд: 1-рт: НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх босгыг 10.0 сая төгрөг байсныг 50.0 сая төгрөг

⁶ Татварын алба улсын хэмжээнд нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдсэн болон бүртгэлээс хасагдсан хувь хүн, хуулийн этгээдийн жагсаалтыг татварын албаны цахим хуудсаар улирал бүр мэдээлнэ.

⁷ Татварын улсын байцаагч нар “НӨАТ суутган төлөгч байгууллага мөн эсэхийг ялгах наалтыг худалдаа, үйлчилгээний газруудын үүдэнд наадаг боловч зарим байгууллагууд уг наалтыг хуулаад авчихдаг тохиолдол гардаг байна.

⁸ Сум тус бүрээр ангилах. Мөн аль нь НӨАТ-тай болон сугалааны дугаартай баримт өгөх, аль зөвхөн сугалааны дугаартай баримт өгөхийг тодорхой болгох шаардлагатай.

болгосон, 2-рт “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч”⁹ нарт тэдгээрийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ын 20 хувийг буцаан олгодог болсон. Эдгээр бодлогын өөрчлөлт нь татвар төлөлтийн байдалд хэрхэн нөлөөлснийг тооцож үзэх зорилгоор НӨАТ суутган төлөгчдийн тоог 2015¹⁰, 2016¹¹ оноор харьцуулж үзэхэд НӨАТ суутган төлөгчийн тоо 11.7 хувь буюу 36-аар цөөрсөн хэдий ч НӨАТ суутган төлөгчдийн тайлагнасан борлуулалтын орлогийн хэмжээ 61.1 хувь буюу 21,980.9 сая төгрөгөөр нэмэгджээ. Эндээс үзвэл НӨАТ-ын хууль тогтоомжид орсон бодлогын өөрчлөлт, шинэчлэлт нь НӨАТ суутган төлөгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа үнэн зөв, ил тод болоход мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлсэнийг харуулж байна.

Дэд зорилт-2. Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт тавигдах хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

2

БҮЛЭГ 2

НӨАТ-ын буцаан олголт тавигдах хяналтыг СЯ, ТЕГ-т хэрэгжүүлж байгаа бөгөөд Маргаан таслах зөвлөлд ирүүлсэн НӨАТ-ын хасалттай холбоотой гомдлыг журмын дагуу шийдвэрлэсэн байна.

НӨАТ-ын буцаан олголттой холбоотой гомдол орон нутгийн татварын албанд ирээгүй байна.

2.1.1. Иргэд буюу НӨАТ төлөгч нарын худалдан авалтад төлсөн НӨАТ-ын 20 хувийг буцаан олгох, түүнд хяналт тавих харилцаа нь СЯ болон ТЕГ-т хэрэгждэг байна. Орон нутгийн татварын албанд Иргэд буюу НӨАТ төлөгч нарын худалдан авалтад төлсөн НӨАТ-ын 20¹² хувийн буцаан олголттой холбоотой гомдол ирээгүй байна.

Татварын маргаан таслах зөвлөл¹³ ирүүлсэн гомдлыг журамд заасан хугацааны дотор хянан шийдвэрлэсэн боловч эрх зүйн үндэслэлгүй акт бичсэн татварын улсын байцаагчид сахилгын шийтгэл ногдуулах саналыг гаргаагүй байна.

⁹ Бараа, ажил, үйлчилгээг аливаа хэлбэрээр борлуулахгүй, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн өөртөө хэрэглэх зориулалтаар худалдан авч, импортоор оруулсан хувь хүнийг албан татвар төлөгч гэнэ

¹⁰ 2015 оны эцэст 308 татвар суутган төлөгч иргэн, хуулийн этгээд байна. Эдгээр татвар суутган төлөгчдийн 2016 оны жилийн нийт борлуулалтын орлого 35,995.0 сая төгрөг байна.

¹¹ 2016 оны эцэст 272 татвар суутган төлөгч иргэн, хуулийн этгээд байна. Эдгээр татвар суутган төлөгчдийн 2016 оны жилийн нийт борлуулалтын орлого 57,975.9 сая төгрөг байна.

¹² Өөрөөр хэлбэл НӨАТ төлөгчийн худалдан авалтад төлсөн НӨАТ-ын 20 хувь гэдэг нь худалдан авсан бараа, ажил үйлчилгээний үнийн дүнгийн 2 хувьтай тэнцүү гэж ойлгоно.

¹³ Маргаан таслах зөвлөл нь зөвхөн татварын акт, дүгнэлттэй холбоотой гомдлыг хянан шийдвэрлэнэ.

2.2.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт, буцаан олголтын талаар 2016 онд Татварын маргаан таслах зөвлөлд хандсан асуудал гаргаагүй байна. Харин 2015 онд ҮХЭХАТ-тай холбоотой 1, 2017 онд НӨАТ-ын акттай холбоотой 2 гомдол гаргасныг Татварын маргаан таслах зөвлөл хянан, шийдвэрлэжээ.

2.2.2. Сүхбаатар аймгийн татварын хэлтсийн дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөл Татварын улсын байцаагчийн 33,377.5 мянган төгрөгийн төлбөр¹⁴ ногдуулсан 2015 оны 02 сарын 23-ны өдрийн 120016615 тоот акттай холбоотой гомдлыг хянаад¹⁵ 27,722.7 мянган төгрөгийн төлбөрийг хасч, 5,654.8 мянган төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр актыг өөрчлөн тогтоосон байна.

2.2.3. Дээрх хууль зүйн үндэслэлгүй акт бичсэн байцаагч нарт Татварын ерөнхий хуулийн 73.2-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг Маргаан таслах зөвлөлөөс гаргаагүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам"-ын 2.1.6¹⁶-д заасантай нийцэхгүй байна.

2.2.4. Сүхбаатар аймгийн татварын хэлтсийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлд 2015-2017 онуудад 3 гомдол гаргасан бөгөөд тэдгээр гомдлыг журамд заасан хугацаанд¹⁷ хянан шийдвэрлэсэн байна. Хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

№	Татвар суулган төлөгч	Актын дугаар	Мөнгөн дүн /сая төгрөг/	Акт тогтоосон огноо	Гомдол гаргасан огноо	Татварын нэр төрөл	Гомдлыг хүлээн авсан огноо	Маргаан таслах зөвлөлийн тогтоолын огноо	Шийдвэрлэхэд зарцуулсан хоног
1	Гэгээн харваах	120020896	36.36	12/23/2016	1/22/2017	НӨАТ	2/3/2017	3/27/2017	52
2	Мөнхийн гэгээвч	120020898	16.64	12/31/2016	1/30/2017	НӨАТ	1/31/2017	3/27/2017	55
3	Баруун-Урт дулааны станц АӨЗ	120016615	33.38	2/23/2015	3/24/2015	ҮХЭХАТ	3/24/2015	4/22/2015	29

---oOo---

¹⁴ Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвартай холбоотой

¹⁵ 2015 оны 04 сарын 22-ны өдрийн №01 тогтоолоор

¹⁶ Татварын акт, дүгнэлт хууль зүйн үндэслэлгүй болох нь тогтоогдвол түүнийг бичсэн татварын улсын байцаагчид Татварын ерөнхий хуулийн 73.2-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг Татварын ерөнхий газрын даргад тавих.

¹⁷ "Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам"-ын 4.1. Маргаан таслах зөвлөл нь энэ журмын 1.7-д заасан шаардлагыг хангасан гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл зөвлөлийн дарга уг хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ❖ Үйл ажиллагааны борлуулалтын орлого нь НӨАТ-ын босго давсан зарим иргэн, хуулийн этгээд НӨАТ суутган төлөгчөөр хуульд заасан хугацаанд бүртгэгдээгүй нь татварын алба тогтмол хяналт тавьж ажиллаагүйтэй холбоотой байна.
- ❖ Шинэ орон сууц худалдан авсан зарим иргэдэд тухайн орон сууцыг барьж, борлуулсан иргэн, ААНБ-ууд НӨАТ-тай төлбөрийн баримт өгөөгүй байна.
- ❖ Худалдаа, үйлчилгээ эрхэлж буй иргэн, ААНБ-уудын аль нь зөвхөн сугалааны тохиролтой баримт өгөх, ямар нь НӨАТ-тай төлбөрийн баримт өгөх ёстой талаарх мэдээлэл, ойлголт иргэд, олон нийтэд дутмаг байна.
- ❖ НӨАТ-ын хууль тогтоомжид орсон бодлогын өөрчлөлт, шинэчлэлт нь НӨАТ суутган төлөгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа үнэн зөв, ил тод болоход мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлсэн байна.
- ❖ Татварын маргаан таслах зөвлөл ирүүлсэн гомдлыг журамд заасан хугацааны дотор хянан шийдвэрлэсэн боловч эрх зүйн үндэслэлгүй акт бичсэн татварын улсын байцаагчид сахилгын шийтгэл ногдуулах саналыг гаргаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

- ❖ НӨАТ-ын шинэ хууль тогтоомж хэрэгжсэнээс хойш шинэ орон сууц борлуулсан иргэн, ААНБ-ууд нь НӨАТ-аа үнэн зөв тайлагнасан эсэх, НӨАТ-тай төлбөрийн баримтыг худалдан авагч нарт тухай бүр өгсөн эсэх талаар хяналт шалгалт¹⁸ явуулах.
- ❖ Сүхбаатар аймагт НӨАТ ногдох үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдүүдийг НӨАТ суутган төлөгч мөн, бишээр нь ангилж¹⁹ олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд сар бүр тогтмол мэдээлж байх.
- ❖ Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны борлуулалтын орлого нь НӨАТ-ын босго давсан эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах.

---oOo---

¹⁸ Тухайн орон сууцыг барьж, борлуулсан иргэн, хуулийн этгээдийн аль татварын албанд бүртгэгдсэн байдлыг харгалзан харьяаллын дагуу шийдвэрлэх, шийдвэрлүүлэх зарчмыг баримтлах нь зүйтэй.

¹⁹ Сум тус бүрээр ангилах.

ҮАГ-ГАГ/2017/08-ГА-СБА
Гүйцэтгэлийн аудитын тайлан

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



СҮХБААТАР АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС

22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг
Утас, Факс: 70518484

2017.08.29 № 222
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Нэмэгдсэн өртөгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн”-ийн талаарх танай байгууллагаас ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцаж саналгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ М.ЭРДЭНЭ



АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1-дэх заалтын дагуу “Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал авахаар хүргүүлсэн.

Сүхбаатар аймгийн Татварын хэлтэс 2017 оны 08 сарын 29-ний өдрийн 222 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Ирүүлсэн саналд дараах тайлбар хийлээ. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй ба дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн тул тайланд нэмэлт өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзэв.

Тайлан бичсэн:

Ахлах аудитор *Г.Оюунболд* Г.Оюунболд


Аудитор *О.Барчидгүнсэн* О.Барчидгүнсэн Аудитын менежер

Аудитор *Э.Алтансүх* Э.Алтансүх

Хянасан:

Тэргүүлэх аудитор *М.Нарантуяа* М.Нарантуяа

Г.Даваа





СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/09

Баруун-Урт

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 03-р сарын 27-ны өдрийн 121 тоот тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн 5, 11, “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12 дугаар зүйлийн 12.40, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Тус аудитаар илрүүлсэн зөрчлийг арилгуулах албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.


Гурав. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны дотор ирүүлэхийг Сүхбаатар аймгийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



D:/Bichig hereg/2017/tushaal

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2017 оны 08 сарын
29-ны өдрийн 4/09 тоот тушаалын хавсралт



“Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын
хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудит

Дугаар	Албан шаардлагын төрөл, код		Алдаа, зөрчлийн товч утга	Албан шаардлагын товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/
1/68	Албан шаардлага	ҮАГ-ГАГ/2017/08-ГА-СБА	Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ 50.0 сая төгрөгт хүрч НӨАТ суутган төлөгч болсон Жигүүрт хүлэг ХХК, Далан шулуун ХХК, Онгон-Арвижих ОНӨҮГ, Халзан дулаан ОНӨҮГ-ууд хуульд заасан хугацаанаас хойш НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдсэн	НӨАТ-ын тухай хуулийн 6.1-д заасан хугацаанд НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлээгүй дээрх ААНБ-уудад татварын хяналт шалгалт хийж, дутуу тайлагнасан НӨАТ-ыг нөхөн төлүүлэх.	-
2/69	Албан шаардлага	ҮАГ-ГАГ/2017/08-ГА-СБА	НӨАТ төлөгч нарт төлбөрийн баримт тогтмол өгдөггүй НӨАТ суутган төлөгч нарыг сонгон авч, тэдгээр НӨАТ суутган төлөгч нарын борлуулалтын орлогыг ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-уудынхтай харьцуулалт хийхэд “Жавхлант сүхбаатар” ХХК-ийн тайлагнасан борлуулалтын орлогын хэмжээ анхаарал татахуйц бага буюу өндөр эрсдэлтэй гарсан	“Жавхлант сүхбаатар” ХХК-ийн НӨАТ төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх.	-

--- ооо ---